

2020 оны жилийн тайлан

“ЛэндМН ББСБ” ХК



Агуулга

Компанийн тухай	04
Бизнесийн үйл ажиллагаа	10
Санхүүгийн үйл ажиллагаа	17
Эрсдэлийн удирдлага	22
Компанийн засаглал	25

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



“

Монголын финтек салбарын анхны нээлттэй бонд болох "Лэнд Бонд"-ыг хөрөнгийн зах зээлд амжилттай гаргалаа.

”

Эрхэм хүндэт хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч байгууллагууд болон харилцагчид та бүхний энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилж байна.

"ЛэндМН ББСБ" ХК нь ололт амжилт, хөгжил дэвшлээр дүүрэн 2020 оны санхүү, үйл ажиллагааны тайланг та бүхэндээ хүргэж байгааг хүлээн авна уу.

Дэлхий даяар хурдацтай тархаад буй COVID-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй энэ цаг үед харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон компанид ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хариу арга хэмжээг цаг тухай бүр шуурхай авч хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй нэгдсэн тогтолцоог бүрдүүлж ажиллаа.

Монгол улс болоод дэлхий дахинд эдийн засгийн хямрал үргэлжилж, хатуу хөл хорио тогтоож, байгууллага төдийгүй иргэдэд хүндрэл үүссэн эгзэгтэй цаг үеийг туулж байна. Бид Монгол Улсын хууль, Засгийн Газрын тогтоол, шийдвэрүүдийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, боломжит бүх хэлбэрээр энэхүү эрсдэлтэй, эдийн засгийн бэрхшээлтэй цаг үеийг харилцагчдаа дэмжих, хамтдаа хамгийн бага эрсдэлтэйгээр даван туулахаар хичээнгүйлэн ажилласан жил болж өнгөрлөө.

"ЛэндМН ББСБ" ХК нь 2020 онд зээлийн багцын чанарт анхаарч, зохих шат дараалсан арга хэмжээг авч ажилласан бөгөөд зээлийн эргэн төлөлтийн уян хатан нөхцөлийг санал болгосон төдийгүй харилцагчид санхүүгийн нэмэлт дарамт учрахаас хамгаалах буюу харилцагчийн зээлийн эрсдэлийг тодорхойлж, зээл эрсдэхээс урьдчилан сэргийлэх хяналтыг хиймэл оюун ухаанд тулгуурлан харилцагчийн скоринг тооцон, харилцагчийн санхүүгийн чадавхид тохирох бүтээгдэхүүнийг санал болгосон билээ.

"ЛэндМН ББСБ" ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д заасны дагуу 2020 оны жилийн эцэст 1.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 3.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 130%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2020 оны 3 сарын 5-нд гаргасан уриалгыг "ЛэндМН ББСБ" ХК хүлээн авч технологийн шийдэл, цахим хэрэгслийг ашиглан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа LendMN фейсбүүк хуудсаар шууд дамжуулан, хувьцаат компаниуд дундаас хамгийн анх удаа "Цахим хэлбэр"-ээр амжилттай зохион байгуулсан. Энэ нь Монгол улсын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн анх удаа цахим хэлбэрээр зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн хурал болж, түүх болон тэмдэглэгдэн үлдлээ. Дэлхийн хөрөнгийн зах зээл, банк санхүүгийн байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн мэдээ мэдээллийг бие даасан хараат бус байдлаар тэнцвэртэйгээр дэлхийн 200 гаруй улс оронд зэрэг нэгтгэн хүргэдэг Global Banking & Finance Review® байгууллагаас жил бүр орон орны банк, санхүүгийн оны шилдгүүдийг тодруулдаг бөгөөд Global Banking & Finance Awards® –аас Банк Бус Санхүүгийн байгууллагын салбарын төрөлд 2020 оны Монголын Шилдэг Финтек компаниар "ЛэндМН ББСБ" ХК-ийг тодруулан

өргөмжилсөн баярт мэдээг дуулгахад таатай байна. 2020 оны 3 сарын 11-ний өдөр "ЛэндМН ББСБ" ХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх тусгай зөвшөөрлийг авсан болно.

"ЛэндМН ББСБ" ХК-ийн охин компани болох "Супер Ап Хэтэвч" ХХК нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас "Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлөө авсан нь бидний хувьд үйл ажиллагаагаа тэлсэн онцлох үйл явдал байлаа.

Түүнчлэн бид нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилсэн энэхүү хариуцлагатай үед Монголын финтек салбарын анхны нээлттэй бонд болох "Лэнд Бонд"-ыг хөрөнгийн зах зээлд амжилттай гаргаж, олон нийтээс 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүллээ. Үүнтэй холбогдуулан андеррайтер компаниудтай хамтран олон нийтэд хөрөнгийн зах зээлийн онцлог, давуу талууд болоод санхүүгийн бусад хэрэгслүүдийг таниулах, сурталчлах ажлуудыг амжилттай зохион байгуулж "ЛэндМН ББСБ" ХК нь салбартаа анхдагч, тэргүүлэгч гэдгээ дахин нотоллоо. Мөн олон улсад өргөн хэрэглэгддэг худалдан авалтын зээлийн SupPAY үйлчилгээг нэвтрүүлж хэрэглэгчдэдээ хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ урьдчилгаа төлбөр төлөхгүйгээр шууд аваад, төлбөрөө 30 хоногийн хугацаанд хүүгүй, шимтгэлгүйгээр эргэн төлөх таатай нөхцөлийг олгосон.

Бид өөрсдийн хувьцааны (MSE: LEND) хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор олон улсад нийтлэг авч хэрэгжүүлдэг хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг боловсруулан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлаар батлууллаа. Компанийн зүгээс хөрөнгийн зах зээлийн арилжааны идэвх буурч буй энэ үед хувьцааны худалдан авалтыг дэмжсэнээр хувьцааны хөрвөх чадвар нэмэгдэн, компанийн үнэлгээг хэт доогуур үнэлэгдэхээс сэргийлэхээс гадна хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах чухал ач холбогдолтой шийдвэр хэмээн үзэж "ЛэндМН ББСБ" ХК нь хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг зарласан. Энэхүү хөтөлбөр нь хувьцаа эзэмшигчдэд маань багахан ч болов хувь нэмэртэй байх болов уу хэмээн итгэж байна. Үүнээс гадна Банк санхүүгийн салбарын хөгжлийн түвшинг тодорхойлогч "AsiaMoney" сэтгүүлээс 2020 оны Монголын шилдэг дижитал банкаар LendMN-ийг тодруулж, 2 дахь удаагаа энэхүү нэр хүндтэй шагналыг гардан авлаа.

2020 онд бидний хувьд харилцагчидтайгаа хамтран эдийн засгийн хүндрэлтэй цаг үеийг хамтдаа даван туулахад чиглэсэн олон олон боломжуудыг эрэлхийлсэн, харилцагчдад учирсан бэрхшээлүүдийг илүү уян хатан байдлаар түргэн шуурхай шийдэхийг зорьсон, харилцагчдадаа чиглэсэн шинэ боломжуудыг олгосон сорилт дүүрэн жил болж өнгөрлөө.

Гэсэн хэдий ч эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг амжилттай даван туулан, ашгийн зорилтот түвшиндээ хүрч "ЛэндМН ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хурлын 21/05 тогтоолоор өмнөх жилүүдийн жишигийн дагуу 2020 оны компанийн цэвэр ашгийн 20%-ийг нийт хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэлээ.

Эрүүл мэнд болон эдийн засгийн эрсдэлтэй энэхүү цаг үеийг хамтдаа хамтран даван туулж, биднийг үргэлж дэмждэг харилцагч, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид та бүхэндээ баярлалаа.

Хүндэтгэсэн:

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирал
О.Болдбаатар

Компанийн тухай





ҮНЭТ ЗҮЙЛС

Шилдэг баг хамт олон, дэвшилтэт технологи дээр суурилсан үйлчилгээ, харилцагчийн итгэл найдвар, илүү ихийг хүсэн мөрөөдсөн, хүлээлгэсэн итгэл нь ЛэндМН-ийн үнэт зүйл байна.



АЛСЫН ХАРАА


Дэвшилтэт технологи дээр суурилсан, дэлхийн энтэй санхүүгийн үйлчилгээний хөтөч байна.




ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн үйлчилгээнд бүрэн хамрагдаж чаддаггүй хүмүүст хүрэх шинэлэг үйлчилгээгээр хэрэглэгчдээ хангасан нийгмийн хариуцлагыг гүнээ ухамсарласан хамт олон байна.


2020 оны онцлох үйл явдлууд



Монголын финтек салбарын анхны нээлттэй бонд болох "Лэнд Бонд"-ыг хөрөнгийн зах зээлд амжилттай гаргаж, олон нийтээс 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээ.



"ЛэндМН ББСБ" ХК зээлийн харилцагчдадаа зориулан хуримтлагдсан бонус оноогоо ашиглаж одоо байгаа зээлийнхээ шимтгэлийг буруулах боломж болон бонус оноогоороо хэмнэлттэй худалдан авалт хийх боломжуудыг тус тус олгож ажиллалаа.



Худалдан авалтын зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргалаа. Олон улсад өргөн хэрэглэгддэг худалдан авалтын зээлийн SupPAY үйлчилгээг нэвтрүүлж хэрэглэгчдэдээ хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ урьдчилгаа төлбөр төлөхгүйгээр шууд аваад, төлбөрөө 30 хоногийн хугацаанд ямар ч хүү, шимтгэлгүйгээр эргэн төлөх таатай нөхцөлийг олголоо. Энэхүү худалдан авалтын зээлийн үйлчилгээг SuperUp аппликейшнээр дамжуулан авах боломжийг бүрдүүлэн ажиллалаа.



"ЛэндМН ББСБ" ХК нь цахим хэтэвч болон төлбөрийн үйлчилгээгээ Монгол банкны тусгай зөвшөөрөл эзэмшигч "Супер Ап Хэтэвч" ХХК-д шилжүүлээ.




Investor relation- хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрт нэгдэн дэмжиж ажиллахаар боллоо.




2020 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн бирж дээр олон нийтэд нээлттэй танилцууллаа.



"ЛэндМН ББСБ" ХК хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг зарлалаа.



"ЛэндМН ББСБ" ХК бүх ажилтнуудынхаа хамтаар зүрхний төрөлхийн гажиг оноштой хүүхдүүдийг эх орондоо үнэ төлбөргүй эмчилж Монголын ирээдүй болсон бяцхан үрсэд амьдрал бэлэглэх зорилготой "Зүрх мартаггүй" төслийг дэмжиж, өөрсдийн нэг өдрийн цалингаа хандивлан шинэ оны босгон дээр нэгэн бяцхан зүрхэнд амьдрал бэлэглэлээ.



Банк санхүүгийн салбарын хөгжлийн төвшинг тодорхойлогч "AsiaMoney" сэтгүүлээс 2020 оны Монголын шилдэг дижитал санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээр LendMN-ийг тодруулж, энэхүү нэр хүндтэй шагналыг 2 дахь удаагаа гардан авлаа.

Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө



60
ЖИЛ

Нэг хэрэглэгч зээл авахад хамгийн багадаа 3 цаг зарцуулдаг гэж үзвэл бид онлайнаар хамгийн шуурхай зээлийн үйлчилгээг үзүүлснээр 175 мянган харилцагчийн зээл авахад зарцуулах 525 мянган цаг буюу 60 жилтэй тэнцэх хугацааг хэмнэх боломжийг олгожээ.



1730
МОД

Нэг удаагийн зээл олголтод дунджаар 15 хуудас цаас зарцуулдаг. Бид 940 мянган удаагийн зээлийг цахим хэлбэрээр баримт бүрдүүлэхгүй олгосноор 72,2 тонн цаас хэмнэж 1730 ширхэг мод аварчээ.



210.5
Тэрбум
төгрөг

Барьцаагүй зээлийн үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчдийн 210.5 тэрбум төгрөгийн эд хөрөнгө, нэр хүндээ барьцаалах үйлдлээс сэргийлж, барьцаа хөрөнгийн асуудлыг бүрэн шийдвэрлэлээ.



438
Сая төгрөг

Хэрэглэгчдэд хэтэвчийн үйлчилгээг шимтгэлгүй үзүүлснээр нийт 438 сая төгрөгийн банкны шимтгэлийн зардлыг хэмнэжээ.

Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө



4.7
Тэрбум
төгрөг

Компанийн хөрөнгө оруулагчдад нийт 4.7 тэрбум төгрөгийн хүү төлсөн байна.



323
Сая төгрөг

Аж ахуй нэгжийн орлогын албан татварт 323 сая төгрөгийг төлсөн байна.



197
Сая төгрөг

Нийгмийн даатгалын шимтгэлд байгууллагаас 113.5 сая, ажилтнуудаас 83.5 сая төгрөгийг төлжээ.



100%
Ажлын
байр

Халдварт цар тахлын үед бид ажлын байрыг 100% хэвээр хадгалж, цалин хөлсийг хугацаанд нь тогтмол олгож ажиллалаа. Бид шинээр бүтэн цагийн 10, гэрээт 24, нийт 34 ажлын байр бий болгон, нийт цалин урамшуулал, хангамж болон тэтгэмжид 2.0 тэрбум төгрөгийг зарцуулжээ.



1.9
Тэрбум
төгрөг

Гуравдагч этгээдээс авсан бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт

- Худалдан авалт болон хамтын ажиллагаа 1.8 тэрбум төгрөг
- Хандив тусламж болон ивээн тэтгэлэг 108 сая төгрөг

Бизнесийн үйл ажиллагаа



2020 оны үзүүлэлтүүд


Бүртгүүлсэн хэрэглэгч
890,481 **25%**
-аар өссөн



Зээлийн харилцагч
175,271 **5%**
-аар өссөн

Олгосон зээлийн тоо

940
мянган удаа




Олгосон зээлийн хэмжээ

210.5
тэрбум төгрөг

Зээлийн үйл ажиллагаа


Гэрээт харилцагчийн тоо



Хүйсийн харьцаа




Насны ангиллаар




Байршлаар


 Улаанбаатар  Орон нутаг




Зээлийн хугацаа сунгасан болон олгосон зээлийн тоо
(Мянган зээл)



Зээлийн хугацаа сунгасан болон олгосон зээлийн дүн
(Тэрбум төгрөг)



Зээлийн багц
(Тэрбум төгрөг)



ББСБ Салбарын зээлдэгчдийн тоо
(2020.III улирлын байдлаар)



SupPAY үйлчилгээ

“ЛэндМН ББСБ” ХК олон улсад өргөн хэрэглэгддэг санхүүгийн бүтээгдэхүүн болох худалдан авалтын зээлийн SupPAY үйлчилгээг нэвтрүүлж эхлээд байна. Бид энэхүү үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчдэдээ хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ урьдчилгаа төлбөр төлөхгүйгээр шууд аваад, төлбөрөө 30 хоногийн хугацаанд ямар ч хүү, шимтгэл гэх нэмэлт төлбөргүйгээр эргэн төлөх таатай нөхцөлийг олгож байна.

27,000

Нийт харилцагчийн тоо



394.5 сая ₮

Зээл олголтын хэмжээ

Та LendMN аппликейшнээр дамжуулан хиймэл оюун ухаан дээр суурилсан хэрэглээний цахим зээлийн үйлчилгээг авдаг бол, худалдан авалтын зээлийн SupPAY үйлчилгээг SuperUp аппликейшнээр дамжуулан авах юм. SuperUp аппликейшний Банана молл онлайн дэлгүүрийн SupPAY тэмдэглэгээтэй 10,000 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээнээс өөрийн сонголтоо хийгээд л шууд авах боломжтой. LendMN аппликейшний хэрэглэгчид SuperUp аппликейшнд өөрийн бүртгэлээрээ шууд нэвтрэх боломжтой бөгөөд SupPAY зээлийн эрхээ тооцуулснаар та хүссэн бүхнээ, хүссэн үедээ гар утаснаасаа захиалаад л хүссэн газраа хүргүүлээд шууд авах боломжтой боллоо.

Бид SupPAY үйлчилгээний нөхцөлийг улам сайжруулж, харилцагчдын хэрэглээнд суурилсан, худалдан авалтын зээлийн хугацааны хувьд хамгийн тохиромжтой, боловсронгуй хувилбаруудыг шинэчлэн нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

SupPAY



Харилцагчийн үйлчилгээний хэлтэс

Харилцагчийн үйлчилгээний хэлтэс нь нийт 28 ажилтнууд хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн ажилладаг бөгөөд 2020 оны турш нийт 636,531 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад үйлчилгээний лавлагааг үзүүлж тэдгээрийн 97.8 %-д амжилттай үйлчлэн асуудлыг нь бүрэн шийдвэрлэсэн байна.

10 сек

Хүлээлгийн
түвшин

637 мянга

Нийт
Дуудлага

97.8%

Амжилттай
үйлчилсэн



47 мянга

Сошиал сувгаар
үйлчилсэн /PM/



41 мянга

И-мэйлээр
үйлчилсэн




46 мянга


Мессэжээр
үйлчилсэн



Хүний нөөц



Хүйсийн харьцаа



29.3 Дундаж нас



БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

92%
Дээд

8%
Бүрэн дунд

— Санхүүгийн үйл ажиллагаа




2020 оны үзүүлэлтүүд

Нийт актив
40.7
тэрбум төгрөг



Зээлийн багц
28.1
тэрбум төгрөг

Нийт орлого
16.4
тэрбум төгрөг




Цэвэр ашиг
2.4
тэрбум төгрөг


Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан /аудитлагдсан/


MNT'000	2018	2019	2020
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,218,150	2,382,196	10,348,101
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	19,642,921	51,009,394	28,774,339
Зээлийн эрсдэлийн сан	(443,555)	(1,551,718)	(3,343,379)
Бусад хөрөнгө	260,086	4,756,978	3,442,271
Үндсэн хөрөнгө	387,784	1,162,101	1,110,983
Биет бус хөрөнгө	258,051	342,002	403,145
Нийт хөрөнгө	24,323,437	58,100,953	40,735,460
Бондын өглөг	6,565,017	3,601,164	7,735,360
Итгэлцлийн үйлчилгээний өглөг		13,845,212	10,506,903
Банкны болон бусад зээлийн өглөг	3,527,400	21,133,646	2,873,337
Цахим хэтэвчээрх өглөг	682,695	964,265	1,217,799
Бусад өглөг	193,950	1,358,188	688,243
Нийт өр төлбөр	10,969,062	40,902,475	23,021,642
Хувьцаат капитал	10,756,859	10,490,773	9,767,920
Бусад	57,348	57,348	57,348
Хуримтлагдсан ашиг	2,540,168	6,650,357	7,888,550
Нийт эздийн өмч	13,354,375	17,198,478	17,713,818
Нийт өр төлбөр болон эздийн өмч	24,323,437	58,100,953	40,735,460

Нэгтгэсэн орлого, үр дүнгийн тайлан /аудитлагдсан/

MNT'000	2018	2019	2020
Шимтгэл болон түүнтэй адилтгах орлого	7,143,319	18,321,082	16,377,802
Хүүгийн зардал	(511,934)	(4,654,241)	(4,723,510)
Цэвэр орлого	6,631,385	13,666,841	11,654,292
Зээлийн болзошгүй эрсдлийн нөөцийн зардал	(408,525)	(1,618,802)	(2,360,681)
Үйл ажиллагааны цэвэр орлого	6,222,860	12,048,039	9,293,611
Удирдлагын болон ҮА-ны зардал	(3,278,064)	(6,016,664)	(6,538,131)
IPO-той холбоотой нэг удаагийн зардал	(79,446)		
Нийт зардал	(3,357,510)	(6,016,664)	(6,538,131)
Татварын өмнөх ашиг	2,865,350	6,031,375	2,755,480
Татварын зардал	(305,037)	(1,121,186)	(323,287)
Цэвэр ашиг	2,560,313	4,910,189	2,432,193

Нийт актив, пассив
(Тэрбум төгрөг)

■ Нийт актив ■ Нийт пассив

Нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж
(Хувь)

■ Нийт хөрөнгийн өгөөж ■ Өөрийн хөрөнгийн өгөөж

Орлого болон Цэвэр ашиг
(Тэрбум төгрөг)

■ Зээлийн үйл ажиллагааны орлого ■ Цэвэр ашиг

— Эрсдэлийн удирдлага



Эрсдэлийн Удирдлага

“Лэндмн ББСБ” ХК нь Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгож, бэхжүүлэхийн тулд Эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу “Гурван шатлалт хамгаалалт”-ыг бүрдүүлж өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн хэм, хэмжээг тодорхойлсон нь компанийн бизнесийн стратеги төлөвлөгөөтэй нийцүүлэн, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байгаа нь компанийн найдвартай байдлыг нэмэгдүүлж байна.

Нөгөөтэйгүүр эрсдэлийг зохистой хэмжээнд удирдах, эдийн засаг, зохицуулалтын орчин, өрсөлдөөн дэх хөгжил, хариу үйлдэл, өөрчлөлтөд бэлэн байх зэрэг төлөвлөгөөг боловсруулахад гол үүрэг гүйцэтгэдэг.

“ЛэндМН ББСБ” ХК нь COVID-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй энэ цаг үед харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон компанид ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хариу арга хэмжээг цаг тухай бүр шуурхай авч хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй нэгдсэн тогтолцоог бүрдүүлж ажиллаа.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн эрдэлийн удирдлагын хүрээнд Эрсдэлийн удирдлагын бодлого, Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого, Эх үүсвэрийн төлөвлөгөө, Зээл түүнтэй адилтгах, активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлогын хэрэгжилтийг ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын хороо хэлэлцэн дүгнэдэг.

Тайлант жилд зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд зээлийн багцын чанарт анхаарч, зохих шат дараалсан арга хэмжээг авч ажиллалаа. Энэ нь санхүүгийн хүндрэлд орсон харилцагч нартаа зээлийн эргэн төлөлтийн уян хатан нөхцөлийг санал болгосон төдийгүй харилцагчийн ирээдүйд үүсч болох зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хиймэл оюун ухаанд тулгуурлан харилцагчийн скоринг тооцож, тухайн харилцагчид тохирох зээлийн бүтээгдэхүүнийг санал болгон ажиллаа.

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2020 оны жилийн эцэст 1.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 3.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 130%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

“ЛэндМН ББСБ” ХК нь “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны журам”, “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ийг шинэчлэн найруулж Гүйцэтгэх захирлын 2020/64 тоот тушаалаар баталлаа.

“ЛэндМН ББСБ” ХК нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг өдөр тутмын үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлснийг Санхүүгийн зохицуулах хорооноос үнэлэн, олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага болох FATF нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу “Саарал жагсаалт”-аас Монгол улсыг гаргах эсэх газар дээрх хяналт шалгалтад нийт Банк бус санхүүгийн салбарыг манлайлж, төлөөлөл болж амжилттай оролцлоо.

Компанийн үйл ажиллагаа зохистой, үр ашигтай байх, санхүүгийн тайлагнал үнэн зөв, бодитой байх, хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөж хэвшүүлэх зэрэгт чиглэсэн “Дотоод хяналтын бодлого”-ыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 сарын 23-ны 20/38 тоот тогтоолоор баталснаар эрсдэлийн удирдлагын гурван хамгаалалтын бүсийн тогтолцоог улам бэхжүүлж, дотоод хяналтын чиг үүргийг нэмэгдүүлэх юм.

Мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд 2020 онд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	2018	2019	2020
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа >10%	52.10%	26.00%	52.10%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа >20%	52.10%	26.01%	52.10%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт >8%	38.00%	17.80%	43.20%
Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгох зээл, актив, баталгаа <30%	0.01%	0.04%	0.02%
ББСБ-ийн холбогдох этгээдэд олгох зээл, актив, баталгаа <10%	0.01%	0.03%	0.01%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт) <±40%	0.03%	-5.30%	0.50%

Компанийн засаглал



Компанийн засаглал

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид ‘Компани’ гэх) нь Монгол Улсын хууль, холбогдох хууль тогтоомжууд болон Монгол Улсын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани болохынхоо хувьд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс тус тус гаргадаг засаглалын дүрэм, журам, кодексыг дагаж мөрдөн ажилладаг билээ.

Тус Компани нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл санхүү, хөрөнгийн зах зээлд шинийг санаачлагч, манлайлагч байсаар ирсэн уламжлалаа хадгалж компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх зорилгоор COVID-19 цар тахал дэгдсэн нөхцөл байдалд уялдуулан хувьцаат компаниуд дундаас анх удаа 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид ‘ХЭХ’ гэх)-аа “Цахим хэлбэр”-ээр амжилттай зохион байгуулсан нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн түүхэнд тэмдэглэгдэн үлдэх үйл явдал болов. Тус ХЭХ-аар жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн аудитлагдсан тайлан, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ‘ТУЗ’ гэх)-ийн гишүүдийг улируулан сонгох, ТУЗ-ийн төсвийг батлах, Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, Компанийн өөрийн хөрөнгийг хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх зэрэг олон чухал асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн билээ.

Мөн цар тахлаас үүдэлтэйгээр Монгол Улсын төдийгүй дэлхийн эдийн засаг хумигдаж улс орнуудад эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилсэн 2020 онд Монголын финтек салбарын анхны нээлттэй “Лэнд Бонд”-ыг гаргах асуудлыг ТУЗ-өөрөө шийдвэрлэж, улмаар Монголын хөрөнгийн зах зээлд амжилттай гаргаж олон нийтээс 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүллээ. Түүнчлэн, компанийн хувьцааны хөрвөх чадварыг сайжруулах болоод хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын үнэ цэнийг хамгаалах зорилгоор өнгөрөгч оны дөрөвдүгээр улиралд Компанийн нийт хувьцааны 5 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдаж авах ажлыг амжилттай зохион байгуулав.

Компани нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийг улирал бүр олон нийтэд тайлагнан, ХЭХ болон ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоол, шийдвэрийг тухай бүр нээлттэй мэдээлэн ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



ТУЗ-ийн дарга

Ц.ОДМАА

“Анд Системс” ХХК-ийн
ТУЗ-ийн дарга



ТУЗ-ийн ердийн гишүүн

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

“АНД Системс” ХХК-ийн
Үйл ажиллагаа хариуцсан захирал
ЭУХ-ны дарга



ТУЗ-ийн ердийн гишүүн

О.БОЛДБААТАР

“ЛэндМН ББСБ” ХК-ийн
Гүйцэтгэх захирал
ЭУХ-ны гишүүн



ТУЗ-ийн ердийн гишүүн

В.БАЯРСАЙХАН

“Томъёо Эд Тек” ХХК-ийн
Ерөнхий захирал
ЭУХ-ны гишүүн



ТУЗ-ийн ердийн гишүүн

Н.ЦЭВЭГМИД

“Мирэ Эссет Секьюритис
Монгол ҮЦК” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
ЭУХ-ны гишүүн
Аудитын хорооны гишүүн



ТУЗ-ийн ердийн гишүүн

С.ЭНХ-АМГАЛАН

ЗНДЦУХ-ны дарга



ТУЗ-ийн хараат бус түр гишүүн

Б.ӨЛЗИЙБАЯР

“Ард Капитал Групп ҮЦК” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
ЭУХ-ны гишүүн
ЗНДЦУХ-ны гишүүн



ТУЗ-ийн хараат бус гишүүн

С.БОРГИЛ

“Сэргэлт Консалтинг Групп” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
Аудитын хорооны гишүүн
ЗНДЦУХ-ны гишүүн



ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ж.ЖАРГАЛСҮРЭН

“Далайван аудит” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
Аудитын хорооны дарга

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

Компанийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, стратегийн зорилтдоо хүрэхэд нь ТУЗ ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх удирдлагад компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.


ТУЗ эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг бүхий 1/ Эрсдэлийн удирдлагын хороо, 2/ Аудитын хороо, 3/ Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороодтой.

2020 оны 3 дугаар сард ХЭХ-аар томилогдсон ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэй ТУЗ хууль дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулж ирлээ. ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Номин 2020 оны 9 дүгээр сард ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ өгсний дагуу ТУЗ тухайн гишүүний хүсэлтийг хүлээн авч, 2020 оны 10 сард хараат бус гишүүнээс чөлөөлсөн. ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалт, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дүгнэлтийг үндэслэн 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн ээлжит бус хурлаар Монгол Улсын иргэн, Ард Капитал Групп ХХК-ийн Гүйцэтгэх захирал Болдын Өлзийбаярыг ХЭХ хуралдах хүртэл хугацаанд ТУЗ-ийн хараат бус түр гишүүнээр томилоод байна.

ТУЗ тогтмол хуралдаж, холбогдох тогтоол шийдвэрийг гарган ажиллаж байгаа ба өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 удаа ээлжит, 7 удаа ээлжит бусаар хуралдаж, нийт 38 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 5 удаа, Эрсдэлийн удирдлагын хороо 4 удаа, Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо 3 удаа тус тус хуралдсан байна.


ТУЗ-өөс Компанийн үйл ажиллагааг зөв зохистой удирдахад чиглэсэн бодлогын бичиг баримтуудыг батлан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллах чиг үүргийнхээ хүрээнд Компанийн Бизнес төлөвлөгөө болон Дотоод хяналтын бодлогыг тус тус батлан гаргалаа.

ТУЗ-ийн хурал, тогтоол




 Хурлын тоо  Шийдвэрийн тоо

ТУЗ-ийн тогтоол



ТУЗ-ийн тогтоолын шийдвэрийн хэрэгжилт



 Хэрэгжсэн  Хэрэгжиж байгаа  Хүлээгдэж байгаа

Эрх бүхий албан тушаалтнууд



О.БОЛДБААТАР

Гүйцэтгэх захирал



Б.УДВАЛ

Дэд захирал



М.ТҮВШИНЖАРГАЛ

Санхүү, үйл ажиллагааны
газрын захирал



М.БЯМБАСҮРЭН


Эрсдэл, Хянан нийцүүлэлтийн
газрын захирал



С.АЗЖАРГАЛ

Ерөнхий нягтлан бодогч

Компанийн бүтэц, зохион байгуулалт



Хувьцааны мэдээлэл


2020 онд "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьцаа 73.3 сая ширхэг 2.4 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 4.8%-ийг эзэлж байна.

Хувьцааны ханш: 31,44


Зах зээлийн үнэлгээ: 24,957,525,039

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020.12.23-ны өдрийн ээлжит хурлын 20/37 тоот тогтоолын дагуу "ЛэндМН ББСБ" ХК нь 2020.12.24-ний өдрөөс эхлэн МХБ-ээс өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авах боломжтой болсон бөгөөд 2020.12.25-ны өдрөөс 2020.12.31-ний өдрийн хооронд нийт 23,856,526 ширхэг хувьцааг худалдан авч халаасаллаа.

Хувьцааны ханш



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж




Хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувь

- Анд Системс ХХК
- Олон нийт
- Халаасны хувьцаа


2020 оны 1 сарын 1-нээс 2020 оны 12 сарын 31 хүртэлх хугацаанд хувьцааны ханш 26% буурсан.

IPO хийснээс хойш нийт 229,574,297 ширхэг, 11,935,871,514₮ үнийн дүнгээр хувьцаа арилжаалагдсан.

Нэгж хувьцаанд ногдох ашиг (Төгрөг)



2020 онд нийт арилжигдсан тоо (Сая ширхэг)



2020 онд нийт арилжигдсан үнийн дүн (Тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Ногдол ашгийн мэдээлэл

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Ногдол ашгийн бодлогын дагуу 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 20/02 тогтоолоор Компанийн 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1.50 төгрөг буюу нийт 1,200,000,000 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг шилжүүлсэн.

2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 21/05 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны цэвэр ашгийн 20% буюу 447,843,214.92 төгрөгийн ногдол ашгийг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны дотор Хувьцаа эзэмшигчдэд хуваарилах, ногдол ашиг хуваарилах Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоохоор шийдвэрлэлээ.

“Лэнд Бонд”-ын мэдээлэл

“ЛэндМН ББСБ” ХК нь Монголын финтек салбарын анхны нээлттэй “Лэнд Бонд”-ыг хөрөнгийн зах зээлд амжилттай гаргалаа.


Бид дэлхийн эдийн засаг хумигдаж улс орнуудад эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилсэн энэ үед Монголын финтек салбарын анхны нээлттэй “Лэнд Бонд”-ыг жилийн 17%-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай Монголын хөрөнгийн зах зээлд амжилттай гаргаж олон нийтээс 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүллээ.

“Лэнд Бонд”-ын андеррайтераар “Ард Капитал Групп” ҮЦК ХХК болон “Мирэ Эссет Секьюритис Монгол” ҮЦК ХХК нар ажиллаж “Райнос Инвестмент” ҮЦК ХХК синдикатаар ажиллалаа.

“Лэнд Бонд”-ын анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг Үнэт цаасны компаниудаар дамжуулан авахаас гадна SuperUp аппликэйшнээр захиалга өгөх боломжтойгоор зохион байгуулсан нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд нэгэн шинэ алхам боллоо.

Бондын анхдагч зах зээлийн арилжаа 2020 оны 6 сарын 15-наас 19-ний өдрийн хооронд 5 хоногийн хугацаанд үргэлжилсэн бөгөөд нийт 541 хөрөнгө оруулагчаас 6.7 тэрбум төгрөгийн захиалга хүлээн авснаар анхдагч зах зээлийн захиалга 134.8%-тай биелж, хамгийн олон захиалагчтай компанийн бонд боллоо.

Хоёрдогч зах зээлийн арилжаагаар 793.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий 7.9 мянган ширхэг бонд арилжигдсан байна





ХОЛБОО БАРИХ:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн
нарийн бичгийн дарга
Ж.Мөнхцэцэг

УТАС:

99018886

ИМЭЙЛ:

board@lend.mn